



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/11/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	7
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 07

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЛБАНЫ ДАРГА Ц.ОДГЭРЭЛ  
ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>30,009,410.00</u></b>	<b><u>42,511,808.00</u></b>
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	30,009,410.00	42,511,808.00
Түүхий эд материал	23,527,910.00	35,842,308.00
Тусгай зориулалттай материал	23,527,910.00	35,842,308.00
<b>Хангамжийн материал</b>	6,481,500.00	6,669,500.00
Бичиг хэргийн материал	84,000.00	72,000.00
Аж ахуйн материал	1,187,800.00	1,187,800.00
Сэлбэг хэрэгсэл	440,000.00	640,000.00
Барилгын засварын материал	3,677,700.00	3,677,700.00
Бусад хангамжийн материал	1,092,000.00	1,092,000.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,506,326,099.89</u></b>	<b><u>1,502,342,521.84</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,506,326,099.89	1,502,342,521.84
<b>Биет хөрөнгө</b>	1,490,286,099.89	1,486,302,521.84
Барилга, байгууламж, орон сууц	1,508,481,908.00	1,508,481,908.00
Хуримтлагдсан элэгдэл	(25,216,323.75)	(50,435,683.35)
Авто-тээврийн хэрэгсэл	14,000,000.00	38,999,700.00
Хуримтлагдсан элэгдэл	(12,055,554.94)	(15,041,654.16)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,665,150.00	8,965,140.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,155,264.57)	(5,933,057.72)
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,567,495.20	4,567,495.20
Хуримтлагдсан элэгдэл	(3,001,310.05)	(3,301,326.13)
<b>Биет бус хөрөнгө</b>	16,040,000.00	16,040,000.00
Бусад биет бус хөрөнгө	16,040,000.00	16,040,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,536,335,509.89</u></b>	<b><u>1,544,854,329.84</u></b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,536,335,509.89</u></b>	<b><u>1,544,854,329.84</u></b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,536,335,509.89	1,544,854,329.84
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,040,000.00	16,040,000.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,280,549,007.25	1,289,067,827.20
Өмнөх үеийн үр дүн	1,280,549,007.25	1,280,549,007.25
Тайлант үеийн үр дүн	-	8,518,819.95
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,746,502.64	239,746,502.64
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,536,335,509.89</u></b>	<b><u>1,544,854,329.84</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>489,697,200.00</b>	<b>688,438,198.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,000,000.00	93,514,098.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>487,679,200.00</b>	<b>594,924,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,679,200.00	594,924,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>510,687,681.53</b>	<b>679,919,378.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>510,687,681.53</b>	<b>679,919,378.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	490,025,850.30	622,735,172.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,834,705.77	436,575,014.00
210101	Үндсэн цалин	277,120,521.77	397,950,125.00
210102	Нэмэгдэл	64,042,030.00	4,626,832.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,672,154.00	23,288,400.00
210104	Урамшуулал	-	10,709,657.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,635,900.00	54,666,479.10
210201	Тэтгэврийн даатгал	31,712,400.00	37,624,246.40
210202	Тэтгэмжийн даатгал	3,730,900.00	4,361,405.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,984,700.00	3,489,124.59
210204	Ажилгүйдлийн даатгал	746,200.00	835,609.31
210205	Эрүүл мэндийн даатгал	7,461,700.00	8,356,093.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,034,685.00	22,152,246.84
210301	Гэрэл, цахилгаан	2,754,346.00	2,950,758.00
210302	Түлш, халаалт	13,516,561.00	16,551,488.84
210303	Цэвэр, бохир ус	4,763,778.00	2,650,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,103,666.00	15,228,275.00
210401	Бичиг хэрэг	1,195,260.00	1,331,625.00
210402	Тээвэр, шатахуун	3,050,000.00	3,052,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	998,406.00	1,118,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,560,000.00	9,469,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	1,080,000.00
210502	Хоол, хүнс	-	1,080,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,524,850.00	62,439,400.00
210604	Урсгал засвар	6,524,850.00	62,439,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	221,000.00	-
210702	Дотоод албан томилолт	221,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	631,362.00	1,310,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00	177,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,612.00	245,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,750.00	59,750.00

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,039,681.53	29,283,268.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	593,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,446,681.53	29,283,268.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,661,831.23	57,184,205.06
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,861,270.00	38,888,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,018,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,861,270.00	4,870,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	14,800,561.23	18,295,705.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,800,561.23	18,295,705.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(20,990,481.53)</b>	<b>8,518,819.95</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(20,990,481.53)</b>	<b>8,518,819.95</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>487,679,200.00</b>	<b>607,436,790.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>487,679,200.00</b>	<b>607,436,790.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	487,679,200.00	594,924,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,679,200.00	594,924,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	12,512,690.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	12,512,690.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>487,359,200.00</b>	<b>607,136,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>487,359,200.00</b>	<b>607,136,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>466,697,368.77</b>	<b>536,359,904.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,834,705.77	436,575,014.00
210101	Үндсэн цалин	277,120,521.77	281,630,995.35
210102	Нэмэгдэл	64,042,030.00	120,520,074.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,672,154.00	34,423,944.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,635,900.00	54,666,479.10
210201	Тэтгэврийн даатгал	31,712,400.00	36,545,038.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,730,900.00	4,530,090.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,984,700.00	3,624,072.45
210204	Ажилгүйдлийн даатгал	746,200.00	906,018.11
210205	Эрүүл мэндийн даатгал	7,461,700.00	9,061,259.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,034,685.00	22,152,246.84
210301	Гэрэл, цахилгаан	2,754,346.00	2,950,758.00
210302	Түлш, халаалт	13,516,561.00	16,551,488.84
210303	Цэвэр, бохир ус	4,763,778.00	2,650,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,028,666.00	15,216,275.00
210401	Бичиг хэрэг	1,120,260.00	1,139,625.00
210402	Тээвэр, шатахуун	3,050,000.00	3,052,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	998,406.00	1,118,800.00
210404	Ном, хэвлэл	-	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,560,000.00	9,559,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,013,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,013,200.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,599,850.00	6,439,400.00
210604	Урсгал засвар	7,599,850.00	6,439,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	221,000.00	-
210702	Дотоод албан томилолт	221,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	736,362.00	1,310,490.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,000.00	177,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	249,612.00	245,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,750.00	59,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	593,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	593,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,661,831.23</b>	<b>70,776,895.06</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,861,270.00	52,481,190.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	12,512,690.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,018,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,861,270.00	5,950,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	14,800,561.23	18,295,705.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,800,561.23	18,295,705.06

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	320,000.00	299,990.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	320,000.00	299,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	320,000.00	299,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	320,000.00	299,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	320,000.00	299,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(320,000.00)	(299,990.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>					-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			21,008,481.53		21,008,481.53
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>16,040,000.00</b>	<b>239,746,502.64</b>	<b>1,280,549,007.25</b>	-	1,536,335,509.89
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>16,040,000.00</b>	<b>239,746,502.64</b>	<b>1,280,549,007.25</b>	-	1,536,335,509.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>16,040,000.00</b>	<b>239,746,502.64</b>	<b>1,280,549,007.25</b>	-	1,536,335,509.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			8,518,819.95		8,518,819.95
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>16,040,000.00</b>	<b>239,746,502.64</b>	<b>1,289,067,827.20</b>	-	1,544,854,329.84

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Нийтлэг үйлчилгээний албаны дарга Ц.Одгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Нийтлэг үйлчилгээний албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлаг болон аймгийн ЗДТГ-ын хэлтэс, алба, төсвийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлж, тэдгээр хэлтэс албадуудыг төрийн үйл ажиллагаагаа хэвийн жигд явуулах нөхцөл бололцоог хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Нийтлэг үйлчилгээний албаны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2020 онд шилэн дансны мэдээллийг байршуулсан эсэхэд улирал бүр хяналт хэрэгжүүлсэн байна. Хяналтын үр дүнгээр 11 зөрчил дутагдалд 12 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 688,438.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,884.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,518.8 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	30,009.40	42,511.80	12,502.40
Үндсэн хөрөнгө	1,506,326.10	1,502,342.50	-3,983.60
Нийт хөрөнгө	1,536,335.50	1,544,854.30	8,518.80
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	16,040.00	16,040.00	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,536,335.50	1,544,854.30	8,518.80

Бараа материалын дансны үлдэгдэл 42,511.8 мянган төгрөг болж 12,502.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,502,342.5 мянган төгрөг болж 3,983.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 25,299.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч, хуримтлагдсан элэгдлийн зардал 29,283.3 мянган төгрөгийг тайлагнаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 24,999.7 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 299.9 мянган төгрөг, нийт 25,299.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 16,040.0 мянган төгрөг, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,040.0 мянга, дахин үнэлгээний нөөц 239,746.5 мянган төгрөгт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Нийтлэг үйлчилгээний албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 198,740.9 мянган төгрөгөөр буюу 40.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 91,514.1 мянга, урсгал санхүүжилт 107,226.9 мянган төгрөгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 169,231.7 мянган төгрөгөөр буюу 33.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 73,770.8 мянга, урсгал засварын зардал 55,914.5 мянга, тэтгэмж 36,522.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 669,891.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 669,891.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74,967.6 мянган төгрөгөөр бууруулж 594,924.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй цалингийн зардал 10,227.9 мянга, тогтмол зардал 13,935.7 мянга, хангамж, бараа материалын зардал 12,627.4 мянга, урсгал засварын зардал 24,213.0 мянга, томилолт 2,084.0 мянга, тэтгэмжийн зардал 22,001.8 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 594,924.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 100% орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 594,924.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 576,628.4 мянган төгрөгийг зарцуулж 18,295.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 576,628.4 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 7,470.7 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 7,212.1 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,260.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Харин хугацаа болоогүй 3 мэдээллийг байршуулаагүй.

Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй байна.

Мөн 5,000.0 мянган төгрөгөөр дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээнээс орлогын гүйлгээг дутуу бол зарлагын 34,018.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,935.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	4	2,935.7	4	2,935.7	0	0	0
Нийт дүн	4	2,935.7	4	2,935.7	0	0	0

/мянган.төг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 92,196.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58,178.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 34,018.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 92,196.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 58,178.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгууллагын даргын тушаалаар сар бүр бүх ажилтнуудад үндсэн цалингийн 25%-иар бодож нийт 57,028.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 4-д "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.", Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно", 7-д "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно" заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан нягтлан бодогч, нярав нарт үндсэн цалингийн 75%-иар бодож 1,149.7 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад үндсэн

шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох” журмын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: албан шаардлага хүргүүлэв.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 34,018.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Нийтлэг үйлчилгээний албаны цалингийн зардлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1.Зардлын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Илүү цагийн хөлсийг байгууллагын даргын тушаалын дагуу бодож олгохдоо 2018 оны Засгийн газрын 382 дугаар тогтоолын “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ыг хийж баталгаажуулаагүй, хаана ямар ажил хийсэн эсэх нь анхан шатны баримтын бүрдлээр бүрэн хангагдахгүй байна.
- 1.2. Эрсдэл: Цалин хөлсийг илүү, буруу тооцоолох
- 1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 382 дугаар тогтоолын “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ыг хийж, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсны дараа илүү цагийн хөлсийг олгож байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

##### *2.Шилэн данстай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: 5,000.0 мянган төгрөгөөр дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээнээс орлогын гүйлгээг дутуу, зарлагын 34,018.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй.

2.2. Эрсдэл: ашиг сонирхлын зөрчил үүсэх.

2.3. Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж, баталгаажуулж, шилэн дансанд мэдээлж байх.

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

Т.БОЛОРМАА

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2021</b>	Аудитын нэр: <b>Нийтлэг үйлчилгээний алба 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ОРА-2021/11/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Нийтлэг үйлчилгээний алба</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын даргын тушаалаар сар бүр бүх ажилтнуудад үндсэн цалингийн 25%-иар бодож нийт 57,028.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон.	57,028.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Одгэрэл, Б.Мөнхдуула л
2	Байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан нягтлан бодогч, нярав нарт үндсэн цалингийн 75%-иар бодож 1,149.7 мянган төгрөгийн урамшууллыг олгосон.	1,149.7	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Одгэрэл, Б.Мөнхдуула л
3	Илүү цагийн хөлсийг байгууллагын даргын тушаалын дагуу бодож олгохдоо 2018 оны Засгийн газрын 382 дугаар тогтоолын "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хийж баталгаажуулаагүй, хаана ямар ажил хийсэн эсэх нь анхан шатны баримтын бүрдлээр бүрэн хангагдахгүй байна.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Одгэрэл, Б.Мөнхдуула л
4	5,000.0 мянган төгрөгөөр дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээнээс орлогын гүйлгээг дутуу, зарлагын 34,018.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй.	34,018.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Одгэрэл, Б.Мөнхдуула л
<b>ДҮН</b>		<b>92,196.5</b>			

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Ц.НАРМАНДАХ**



ОРА-2021/11/СТА-ТШЗ

16

Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР:

Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 20/20 011-2021/11/СТА-ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаалаар сар бүр бүх ажилтнуудад үндсэн цалингийн 25%-иар бодож нийт 57,028.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 4-д "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.", Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаал батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно", 7-д "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ур чадварын нэмэгдлийг бүх ажилтнуудад хавтгайруулан олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтлэг үйлчилгээний албаны дарга Ц.Одгэрэл, нягтлан бодогч Б.Мөнхдуулал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... Т.БОЛОРМАА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/21 ОАА-2021/11/САА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийтлэг үйлчилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан нягтлан бодогч, нярав нарт үндсэн цалингийн 75%-иар бодож 1,149.7 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь сар бүрийн ур чадварын нэмэгдэл, улирал бүрийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2-д "Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшууллыг давхардуулан олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтлэг үйлчилгээний албаны дарга Ц.Одгэрэл, нягтлан бодогч Б.Мөнхдуулал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... Т.БОЛОРМАА